



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2013 оны 4 дүгээр
сарын 4-ний өдөр

Дугаар 55

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. "Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах тухай" Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 123 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Замын-Үүд боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- Ахлагч -Гаалийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Ганбат
- Гишүүд:
-Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ш.Лхачинжав;
-Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын дарга Б.Пүрэвдорж;
-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Гүнбазар;
-Гадаад харилцааны яамны Хил, хилийн боомтын хэлтсийн дарга Р.Бизъяа;
-Сангийн яамны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтсийн дарга М.Батгэрэл;
-Зам, тээврийн яамны Замын барилга, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Х.Ганболд;
-Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг дарга М.Баянмөнх.
- Нарийн бичгийн дарга -Гаалийн ерөнхий газрын дэд дарга Н.Энхцогт.

2. "Замын-Үүд" хилийн боомтын ачааны автомашины шалган нэвтрүүлэх цогцолбор, уг цогцолбороос гаалийн рентген хяналтын талбай хүртэлх 2.3 км хатуу хучилттай авто замын ажлыг 2013 оны 6 дугаар сарын 15-ны дотор, Гаалийн рентген хяналтын талбайгаас төмөр замын шилжүүлэн ачих терминал хүртэлх 8.7 км хатуу хучилттай авто замыг 2013 оны 10 дугаар 15-ны дотор ашиглалтад оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Ажлын хэсэг (О.Ганбат)-т даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Н.АЛТАНХУЯГ